

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/21 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 4.7.6 дахь заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажил олгогч, хамт олны төлөөлөлтэй байгуулсан хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Шинэ жилийн баярыг тохиолдуулан тус байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын хүүхдүүдэд баярын бэлэг гардуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
2. Зардалд шаардагдах 2,477,520 /хоёр сая дөрвөн зуун далан долоон мянган таван зуун хорь/ төгрөгийг холбогдох зардлын зүйл ангиас тооцон гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Очир/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны дарга /Т.Содгэрэл/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.ГАНЦЭЦЭГ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын
2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1/207
дугаар тушаалын 2 хавсралт



Шаардагдах зардал

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ ₮-өөр	Бүгд үнэ ₮- өөр
1	Гарын бэлэг	124	19980	2.477.520
Нийт				2.477.520